ХАН-УУЛ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН 2019 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2019.12.05

| № | Заалт | Хэрэгжилт |
|---|---|---|
| | **Нэг: Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүн** | |
| 1. | Монгол улсын тогтвортой хөгжил үзэл баримтлал-2030”-д заасан нийслэлд хэрэгжих зорилтын хүрээнд тухайн байгууллагаас гүйцэтгэсэн ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл | **Зорилт 1:Халдварт бус өвчнийг бууруулах зорилгоор иргэдийг урьдчилан сэргийлэх шинжилгээ, оношилгоонд үнэ төлбөргүй хамруулах ажлыг үе шаттай зохион байгуулах зорилтийн хүрээнд**<br><br>Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийт салбар хоорондын оролцоог хангаң хэрэгжүүлсэнээр эрт илрүүлгийг нэмэгдүүлсэн. |

| 1 | Үзүүлэлт | | 2017 | 2018 | 2019 оны эхний 10 сар |
|---|---|---|---|---|---|
| | | | **84%** | **88%** | **93,7%** |
| 2 | Артерийн гипертензи үзлэгт анх удаа хамрагдсан хүний тоо | | 32830 | 33986 | 39541 |
| | эрэгтэй | | 12899 | 14819 | 16280 |
| | эмэгтэй | | 19931 | 19931 | 23261 |
| | Давтан үзлэг | | 4176 | 4285 | 2525 |
| | Батлагдсан артерийн даралт | | 146 | 150 | 58 |
| 3 | Чихрийн шижин хэв шинж -2 эрт илрүүлэг үзлэгт анх хамрагдсан хүний тоо | | 25329 | 28599 | 32944 |
| | | | **65%** | **75%** | **78%** |
| | эрэгтэй | | 9528 | 11935 | 13135 |
| | эмэгтэй | | 15801 | 16664 | 19809 |
| | Давтан үзлэг | | 2042 | 2319 | 1949 |
| | Батлагдсан чихрийн шижин | | 32 | 27 | 5 |
| 4 | Умайн хүзүүний үзлэгт эрт илрүүлгийн үзлэг | Хамрагдах хүний тоо | 9997 | 10053 | 12247 |
| | | Хамрагдсан хүний тоо | 3392 | 3297 | 2143 |
| | Хамрагдалтын хувь | | **34.40%** | **33%** | **33%** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Илэрсэн Умайн хүзүүний хавдар | | 0 | 2 | |
| 5 | Хөхний хавдарын эрт илрүүлгийн үзлэг | Хамрагдах хүний тоо | 46707 | 38717 | 51800 |
| | | Хамрагдсан хүний тоо | 16557 | 20322 | 12564 |
| | Хамрагдалтын хувь | | **35.40%** | **52%** | **55%** |
| | Илэрсэн хөхний хавдар | | 1 | 1 | |

- **Эрүүл-зүрх Эрүүл-Улаанбаатар**” уриан доор Артерийн гипертензийн оношлогоо, эмчилгээ, хяналт, зөвлөгөө өгөх, багаар ажиллах, чадварыг сайжруулах, ӨЭМТ-ийн Эмч, ажилчдыг хөдөлгөөний хомсдолоос сэргийлэх, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтнүүд эрүүл мэндээ хамгаалах, урьдчилан сэргийлэхэд уриалсан үйл ажиллагааг зохион байгуулж, Төвийн бүсийн “Мөнхбадрах”, “Тэрмэстий”, “Энхтитэм”, “Амгалан -өрх”, “Мэндсаруул ”ӨЭМТ-үүд “Эрүүл мэнд идэвхитэй хөдөлгөөн” сэдэвт явган аялалыг 2019 оны 04-р сарын 06-ны өдөр “ЧИНГИСИЙН ӨРГӨӨ” цогцолбороос “БОГД ХАН УУЛ, БАРУУН ШИРЭЭТ” хүртэл нийт 4 км үүргэвчтэй явган аялал зохион байгууллаа. Явган аялалаар “Артерийн гипертензийн оношлогоо, эмчилгээ, хяналт” сэдвээр эмч, ажилчид ярилцлага зохион байгуулж, туршлага солилцон, эмч, ажилчдын дунд АХА тэмцээн, хөгжөөнт тоглоом зохион байгууллаа. Мөн Хан-Уул дүүргийн 3-р хорооны харьяа хотхонуудаар “ Эрүүл зүрх” уриан дор өндөр, жин , ХЭТ, БЖИ , Артерийн даралт үзэж зөвлөгөө өгөн, артерийн даралт ихсэлтийг илрүүлэх, хянах зорилгоор нийт 7 хотхоны 210 иргэнд урьдчилан сэргийлэх үзлэг хийлээ
- Артерийн Гипертензийн менежментийн манлайллыг сайжруулах нь” сургалтанд Хан-Уул дүүргийн ЭМТөвийн харьяа Сайн дурын ажилтнууд нийт 48 хүн оролцлоо






- 2019 оны 05 сарын 17-нд цусны даралт ихсэлттэй тэмцэх дэлхийн өдрийг 16 хорооны ӨЭМТ –үүд **“ДАРАЛТ ХЭМЖИЛТИЙГ ДАДАЛ БОЛГОЁ”** уриан дор тэмдэглэн “Цусны даралт ихсэлт буюу “130/80” танилцуулгыг иргэдэд хийж давхардсан тоогоор 562 иргэдийн өндөр, жин, даралтыг үзэн зөвөлгөө өгч зөвлөмж тараалаа. Мөн энэ үеэр тус хорооны ахмадын “Жавхаатай хэмнэл” хийн дасгалын багын ахмадууд дасгал хийж иргэдэд хөдөлгөөн эрүүл мэнд сурталчилгааг хийлээ.






- Нийслэлийн Засаг даргын 2019 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн “**Эрүүл иргэн**” аянг зохион байгуулах тухай А/320 дугаар захирамжийн хүрээнд Хан-Уул дүүрэгт 3 сарын турш үргэлжлэх “Эрүүл иргэн” аян Хан-Уул Эрүүл Мэндийн Төвийн Яармаг салбарын гадна талбайд 2019 оны 05 дугаар сарын 17-ны өдөр нээлтээ хийлээ. Эрүүл иргэн аяны нээлтийн үйл ажиллагааг ХУЭМТ-ийн яармаг салбартай хамтран ХУЭМТ-ийн НЭМА Ч.Гүнчинхорол болон ХУД-ийн ӨЭМТ-ийн НЭМАжилтанууд хамтран зохион байгууллаа. Нээлтийн үйл ажиллагааг дэмжин ЦУСНЫ ДАРАЛТ ИХСЭЛТТЭЙ тэмцэх дэлхийн өдрийг тохиолдуулан МОНОС эмийн үйлдвэр нийт 156 иргэнд хүчилтөрөгчийн коктейлоор үйлчилж ӨЭМТөвүүдийн эмч нар 94 иргэний даралт болон өндөр жин хэмжиж зөвлөгөө өглөө.






Хан-Уул дүүргийн Засаг даргын 2019 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн А/290 дугаар захирамжийн дагуу 09 дүгээр сарын 08-ны өдөр дүүргийн 16 хорооны Өрхийн эрүүл мэндийн төвүүд, хороодтой хамтран “Би эко дүүргийн эрүүл иргэн” өдөрлөг, урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгууллаа. Үзлэгт нийт 1704 иргэн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд үнэ төлбөргүй хамрагдлаа. Элэгний В, С вирус илрүүлэх шинжлгээнд 696 хүн хамрагдаж В вирустэй -11 хүн, С вирустэй-36 хүн оношлосон.





- ӨЭМТөвүүдийн НЭМАжилтнууд 200 гаран иргэнд тараах материал бэлтгэн тараалаа. Аяны хүрээнд Хан-Уул дүүргийн хорооны Эрүүл мэндийн төвүүд дээр дотор, мэдрэл, зүрх судас, ахмад настан, хүүхэд, нүд, чих хамар хоолой, хавдар, сүрьеэ, эмэгтэйчүүд зэрэг төрөлжсөн мэргэжлийн эмч нарын үзлэг, оношлогоог газар дээр иргэдэд үзүүлж, өвчин эмгэгийг эрт оношлуулж, хүндрэлээс иргэдийг урьдчилан сэргийлэх тухай зөвлөмж гарын авлага материал тараалаа.





- “Эрүүл иргэн” аяны хүрээнд хуваарийн дагуу 2019-05-17-нд Мэдрэл-30, зүрх судас-48, ахмад настан 30, хүүхэд 37, нүд-68, чих хамар хоолой-103 , хавдар-18 , БЗДК-38, эмэгтэйчүүд -15 , Эхо- 42 нийт давхардсан тоогоор 429 иргэдийг нарийн мэргэжлийн нарын урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, эрүүл мэндийн боловсрол олгох сурталчилгаа хийлээ.





- “БИ-ЭКО ДҮҮРГИЙН ЭРҮҮЛ ИРГЭН” ӨДӨРЛӨГ Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын 2019 оны 08 сарын 12-ны өдрийн А/290 дүгээр захирамж, Хан-Уул дүүргийн Засаг даргын тамгын газрын 2019 оны 08 сарын 27 -ны өдрийн 07/1710 албан бичгийн хүрээнд 2019 оны 09 сарын 08-ны өдөр 10:00-16:00 цагийн хооронд " Би-Эко дүүргийн эрүүл иргэн" өдөрлөг амжилттай зохион байгууллаа. Уг өдөрлөгт ХУД-ЭМН-ийн дотрын их эмч н.Аюурзана, ХУД-ЭМТ-ийн мэс засал, урлогийн их эмч н.Габит болон 165-р цэцэрлэг их эмч н.Анхтуяа нар хамтран ажилласан. Өдөрлөгөөр В, С вирусын сорилд 50 иргэн, ДОХ тэмбүүгийн сорилд 25, Сахарын сорилд 5 иргэн хамрагдсан бөгөөд дотрын эмчид 36 иргэн, хөхний үзлэгт – 20, умайн хүзүүний эсийн шинжилгээнд 5 иргэн, зүрхний цахилгаан бичлэгийг 12 иргэнд, мэс засал, урлогийн эмчид 18 иргэн, амьжиргааг дэмжих өрхийн эрүүл мэндийн даатгалд баталгаажуулах 7 иргэний мэдээллийг бүртгэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүллээ. Мөн артерийн гипертензийн үзлэгт 35 иргэн, өндөр, жин, биеийн жингийн индексийг 21 иргэнд тодорхойлсон. Идэвхитэй дасгал хөдөлгөөн сургалтыг зохион байгуулсан.

- Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах олон улсын өдрийг тохиолдуулан өдөрлөг зохион байгуулсан. Өдөрлөгийн хүрээнд 38 иргэнд 1 сургалт, 6 төрлийн сурталчилгаа, 152 иргэнд 4 төрлийн үзлэг оношлогоо, 27 иргэнд 76 удаагийн тусламж үйлчилгээ хийгдсэнээр нийт 217 иргэн хамрагдсан байна.







- Дэлхийн бөөр хамгаалах өдрийг "Эрүүл бөөр хаана ч, хэнд ч" гэсэн уриатайгаар Денк фарм, Айвико ХХК, Цахиур төмөр эмийн компануудтай хамтран зохион байгуулж, ЭМТ-ийн амбулаториор үйлчлүүлэгчдэд сургалт сурталчилгаа хийж, 85 хүнийг хамрууллаа. Мөн “Бөөрөө хамгаалья” сэдвээр Нийслэлийн 15-р сургуулийн 9-12 ангийн хүүхдүүдэд, 42-р сургуулийн дунд, бага ангийханд шүдний өвчнөөс сэргийлэх шүдээ хэрхэн арчлах, бөөрөө хэрхэн хайрлан хамгаалах талаар эрүүл мэндийн анхан шатны мэдлэг мэдээлэл олгох сургалтыг 15,3,10-р хорооны ӨЭМТ ийн ЭМНА-ууд, ХУЭМТ-ийн шүдний эмч Төрбат, ХУЭМТ ийн Бөөрний эмч Б.Баярцэцэг нар хамтран зохион байгуулав. ХУЭМТ ийн Бөөрний эмч Б.Баярцэцэг 15-р хорооны Мэнд-саруул, 3-р хорооны Энхтитэм, 10-р хорооны Аминтус ӨЭМТ –үүдтэй хамтран сургалт зохион байгуулж,нийт 118 хүн хамрагдан мэдлэг дадлага хандлагаа сайжрууллаа.







- ЧШӨ-тэй иргэдэд ганцаарчилсан болон бүлгийн сургалтыг ЧШӨ-ний талаархи ойлголт, түүнийг яаж хянах, хүндрэл түүнээс урьдчилан сэргийлэх боломж, хоол хөдөлгөөний дэглэмийн талаархи ойлголтуудыг багтаан биеийн тамирын аргазүйч Д,Соёлмаатай хамтран тогтмол хийж байна.Нийт 14 удаагийн сургалтаар 90 гаруй иргэдийг хамруулсан. ЧШӨ- ний Эрт илрүүлгийг ХУД-ийн 1-р, 3-р хороо болон ХУД-ийн ГЭР бүл Хүүхэд залуучуудын хэлтсийн 20 гаруй ажилчдыг хамруулж, ЧШӨ-ний эрт илрүүлэг хийж, шинээр 7 хүнийг хяналтанд авлаа.




- Олон Улсын сувилагчийн өдрийг угтан СЗЭ-ний сувилахуйн баг АТАР ӨРГӨӨ ХК-тай хамтран "ЭРҮҮЛ ХҮНС-ЗӨВ СОНГОЛТ" уриан дор Сувилагчийн нэг өдрийг зохион байгууллаа.Энэхүү үйл ажиллагаанд тус ХК-н шинжээч У.Хулан, технологич Б.Алтангэрэл, мастер Б.Баасанхүү, лабораторийн эрхлэгч Б.Шинэхүү нар оролцож, иргэдэд нэрийн бүтээгдэхүүний орц найрлага, үзүүлэх үйлчилгээ ,ач тусын талаар сургалт сурталчилгаа хийж, амталгаа зохион байгууллаа.Мөн сувилагч нар нэр бүхий сэдвээр сурталчилгааны материал тараалаа.

  

- Иргэний нисэхийн ерөнхий газрын Холбоо навигацийн албаны ажилтануудад "Зохистой хооллолт" сэдвээр сургалт хийж, сургалтанд нийт 48 хүнийг “Хоол тэжээл болон хүнсний аюулгүй байдлыг хэрхэн хангах сэдэвт сургалтыг 65,49-р цэцэрлэгийн 32 багш ажилчдад Хүүхдийн хоол тэжээл, хүнсний аюулгүй байдал сэдвээр” эцэг эх асран хамгаалагч 152 хүнд тус тус хийсэн байна.

   

- 2019 оны дэлхийн эрүүл мэндийн өдрийг “Давсыг хоолны цэснээс хасъя” уриан дор 2019-03-26-аас 2019-04-02-ны хугацаанд зохион байгуулж тэмдэглэн өнгөрүүлэв. Ажлын хүрээнд ӨЭМТөвүүдтэй хамтран нийт 16 удаагийн сургалтыг 16 хорооны ӨЭМТ болон ХУЭМТөвөөр үйлчилүүлж буй үйлчлүүлэгчид, хэвтэн эмчилүүлэх тасгийн өвчтөнүүдэд, ХУД-ийн 15,75,7,53-р сургуулийн багш ажилчид эцэг эхэд,,65,86-р цэцэрлэгийн багш ажилчид,ИНЕГ-ын холбоо навигацын алба зэрэг албан байгуулагуудад “Давсны хэрэглээ 5 гр-аас хэтрэх ёсгүй”, “Давсны хэрглээг багасгах ямар ач холбогдолтой вэ?”, “Иоджуулсан давсыг хоол хүнсэндээ хэрэглэе”, “Эрүүл зөв хоололт, иоджуулсан давсны хэрэглээ” сэдвүүдээр сургалт хийж нийт 1550 үйлчилүүлэгчид хамрагдав.Гарын авлага,зөвлөмж 4-ийг боловсруулан 1450ш тараав.

| | | |
|---|---|---|
| | |    <br>• 2019 оны 6 сарын 19-ний өдөр Хурд хороололд иргэдэд Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, мэндийн төвийн үйл ажиллагааг сурталчилах ажлыг зохион байгууллаа. Өдөрлөгийн үеэр иргэдийг сахар, хеликобактер, ЗЦБ, дох, тэмбүү, артерийн даралт үзэж, зөвлөгөө өгч, иргэдэд “Халдварт болон халдварт бус өвчлөл”, “Эрүүл зөв хооллолт-давсны хэрэглээгээ бууруулах”, Дасгал хөдөлгөөнөөр хичээллэх талаар мэдээ, мэдээлэл өгч тараах материал тараасан. Нийт 120 хүн хамрагдсан.<br>  |

- 2019 оны 10 сарын 24-ны өдөр 67-р цэцэрлэгийн багш ажилчидад “ХБӨ-ээс хэрхэн сэргийлэх тухай”, “Хоолоо хэрхэн зөв зохицуулах вэ?” сэдэвт сургалтыг Ахлах эмч С.Алтанзагас, их эмч Б.Оюундэмбэрэл нар хамтран зохион байгууллаа.




- Эх хүүхдийн эрүүл мэндийг дэмжих ажлын хүрээнд ХУД-ийн 15-р хороонд байрлах “Миний найзууд”, “Бамбуулай” “Олуулаа”, “Далай”, “Цэцэгхэн”, “Тугалхан”, ”Мөөжиг жөөжиг”, “Бяцхан найзууд 1, 2” мөн 165, 134 зэрэг цэцэрлэгийн нийт 450 хүүхдэд урьдчилан сэргийлэх үзлэг хийж, амны хөндийн эрүүл мэнд, шүдээ эрүүл байлгахын тулд эрүүл зохистой хооллох, жингийн илүүдэлтэй болон хоцрогдолтой хүүхдүүдийг хэрхэн хооллох талаар багш нарт эрүүл мэндийн зөвлөгөө өгч, зөвлөмж тараав. Мөн ӨЭМТөвүүд дээр ДЗОУБ-тай хамтран сургалт зохион байгуулж, “Бага насны хүүхдийн нэмэгдэл хоол хэрхэн бэлдэх”, хоол хийх аргачлалыг зааж өгч, сайн дурын ээж нарыг бэлтгэн ажиллаж байна.
- 2019 оны 10 сарын 23, 31-ны өдрүүдэд Их эмч Б.Жайнагүль, Б.Оюундэмбэрэл, ЭМНА О.Долгорсүрэн нар хүүхдийн хоол тэжээл, хүнсний аюулгүй байдлаас урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн боловсрол олгох зорилгоор “Хүүхдийн хоол тэжээлийн доройтол” “Хүүхдийн өвчин эмгэгүүд” зэрэг сэдвүүдээр ӨЭМТ-н нийт эмч ажилчидад сургалт зохион байгуулан эрүүл зан үйл төлөвшүүлэх сурталчилгаа хийж ажиллалаа.
- “Эхийн сүүгээр хооллох бодлогыг дэмжих Дэлхийн 7 хоног”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх зорилгоор жирэмсэн, хөхүүл эмэгтэйчүүд болон аавуудад “Эхийн сүүний ач тус болон аавуудын оролцоо” сэдэвт сургалт, өдөрлөгийг 2019.08.08 -ны өдөр ХУЭМТ-ийн Яармаг салбарын эмнэлэг дээр Яармаг бүсийн ӨЭМТ-үүд, ХУЭМТ-ийн Яармаг салбар, Denk pharma эмийн компанитай хамтран зохион байгууллаа. Сургалт, өдөрлөгөөр нийт 76 эцэг, эхчүүд хамрагдсан.

- **<u>Хүн амын насжилтыг дэмжих, ахмад настны эрүүл мэндийн тусламж үйлчилгээ</u>**:

ӨЭМТ-үүд ахмадуудын судалгаагаа шинэчлэн нийт 15 төрлийн нарийвчилсан судалгааг гаргаж судалгааны мэдээллийн сантай болсон ба шилжилт хөдөлгөөнийг тухай бүр нь хийж хагас жил тутам тайлагнадаг. Үүнд: Ахмад настан 12327, эмэгтэй-8659, ахмад дайчин 19, 95-с дээш настан-23, нэн ядуу-141, ганц бие 131, тамирчин ахмад -46, хараагүй – 146, байнгын асаргаанд 1498 настан байдаг. Эрүүл мэндийн бүлгээр авч үзвэл:

| | |
|---|---|
| 1-р бүлэг 0 | 4-р бүлэг 3412 |
| 2-р бүлэг 1516 | 5-р бүлэг 124 |
| 3-р бүлэг 7455 | |

2019.04.19- 04.22- ны өдрүүдэд "Эрүүл насжилтын төлөө хамтдаа" аяны хүрээнд 1,2,3,12,13,9-р ӨЭМТ-үүдэд Геронтологийн үндэсний төвөөс настны эрүүл мэндийг дэмжих,хамгаалах,эрүүл зан үйл, эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэх зорилгоор ахмадын нарийн мэргэжлийн эмч нарын баг ирж урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгууллаа. Үзлэгт нийт ахмад настан хамрагдан,бие бялдрын цогц үнэлгээ болон ясны сийрэгжилтийг тодорхойлох,ЭХО, ЭКГ зэрэг оношилгоонд давхардсан тоогоор нийт 4556 ахмад настан хамрагдлаа.






Халдварт болон халдварын бус өвчний эрт илрүүлгийн урьдчилан сэргийлэх үзлэгт ХУЭМТ-ийн нарийн мэргэжлийн эмч нарын баг тус дүүргийн 1-16 хорооны ӨЭМТ дээр графикийн дагуу ажиллаж, давхардсан тоогоор 7735 ахмадуудад урьдчилан сэргийлэх үзлэг хийлээ.. Үүнд ахмад-590, дотор-488, мэдрэл-606, нүд-

602, лор-644, хавдар-546, эхо-836, ДБЗХӨ-1042, эмэгтэйчүүд-425, зүрх судас-638, сүрьеэ-358, ЭКГ-638, флюр-322 хүнийг тус тус хамруулсан





11-р хороо,"АМГАЛАН-ӨРХ" ӨЭМТ, Ахмадын зөвлөл,"Тунгалаг аялгуу" Чих, сонсгол нөхөн сэргээх эмнэлэг хамтран 2019.05.07-ны өдөр тус хорооны ахмадуудаа үнэ төлбөргүй сонсгол шалгах үзлэг, “ТҮРҮҮ БУЛЧИРХАЙН ЭРТ ҮЕИЙН ИЛРҮҮЛЭГ, ОНОШИЛГОО” өдөрлөг зохион байгуулж ахмад настан болон 55-аас дээш насны 260 ахмадад Урологийн эмчийн үзлэг, эхо оношилгоо зохион байгуулж зөвлөгөө, мэдээлэл хүргэж гарын авлага тараалаа.





2019.01.25 нд ахмадын кабинетаас санаачлан “Эрүүл энх урт наслахуй” сэдэвт ахмадуудын нээлттэй өдөрлөг зохион байгуулсан. Тус өдөрлөгөөр ахмадуудын гар урлалын үзэсгэлэн худалдаа, хичээл сургалт, ясны сийрэгжилт тодорхойлох үйл ажиллагаа хийгдэж нийт 120 ахмад настан оролцлоо. Ахмадын эмч Ч.Ганцэцэг нь ахмадуудад зориулж “Эрүүл энх урт наслахуй” ном бичиж 100 ш хэвлүүлж ахмадууддаа тараалаа










2019 оны 05 сарын 17-нд Геронтологийн үндэсний төвийн Гэрийн үзлэгийн багийн хамт олонтой хамтран 5-р бүлгийн 6 ахмадуудын гэрээр үзлэг хийж, иргэдийн дунд эрүүл мэндийн сургалт сурталчилгааг идэвхижүүлэх, аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдлэг мэдээллийг нь сайжруулах, амьдралын зөв дадал хэвшилтэй болгох ажлыг хийж байна.

ОЛОН УЛСЫН СУВИЛАГЧИЙН ӨДӨР"-ийг угтаж ӨЭМТ-ийн сувилагч нар өндөр настан, өөртөө үйлчлэх чадвараа алдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд гэрээр сувилахуйн тусламж үйлчилгээг үзүүллээ. Уг үйлчилгээнд 45 ахмадыг хамруулж зүрхний бичлэг хийж, усанд оруулан массаж хийж, аминдэм тараан өгөх зэрэг тусламж үйлчилгээг үзүүллээ.







- Яармаг бүсийн ӨЭМТ-үүд ахмадаа дэмжих үйл ажиллагааны тайлан өдөрлөийг г 2019 оны 04 сарын 30-ны өдөр 34-р сургууль дээр зохион байгуулж тус өдөрлөгт Хан-уул дүүргийн Наянтай клубын ахмадын төлөөлөл, хорооны засаг дарга, хэсгийн ахлагч нарын төлөөлөл, ӨЭМТ-ийн эмч, сувилагч, хорооны ахмад настан нийт 65 хүн оролцлоо. Өдөрлөгийн үеэр ахмадууд өөрсдийн идэвхитэй

хөдөлгөөн эрүүл мэндийг дэмжих иог дасгал, хөдөлгөөн хийж өөрсдийн чөлөөт цагаар хийсэн гар урлалын бүтээлүүдээр үзэсгэлэн гаргасан.






- 2019.10.03 нд Гериатр их эмч Ч.Ганцэцэг нь “Насжилт, настны эмгэг судлалын тулгамдсан асуудлууд 2019” эрдэм шинжилгээний хуралд “ ХУД-ийн ахмадуудад бие бялдарын хэмжилт хийсэн үр дүнгийн судалгаа” илтгэлээр амжилттай оролцсон.




- ХУЭМТ-ийн ахмадын кабинет нь Геронтологийн ҮТ болон ХУД-ийн ахмадын хороо, “Монфа, “Авико”, “Цахиур төмөр”, “Санто” ХХК-уудтай хамтран ахмадуудад ээлтэй үйл ажиллагаа явуулж ирсэн ба бусад ТББ-уудыг нийгмийн хариуцлагын хүрээнд ахмадуудад чиглэсэн үйл ажиллагаа явуулахыг уриалсан. Үүнд: Ахмадуудын сургалт сурталчилгаа болон өдөрлөг гэх мэт үйл ажиллагаанд хамтран ажилласан.
- 2019.09.24 нд “Настны цогц тусламж үйлчилгээг бэхжүүлэх нь “ сэдэвт сургалтыг ГҮТ-өөс урьж ХУЭМТ-ийн эмч нарт сургалт явуулсан нь үр дүнтэй болсон ба тус сургалтанд 30 эмч нар оролцсон.
- 12. Гериатр их эмч Ч.Ганцэцэг нь “Настны цогц тусламж үйлчилгээг бэхжүүлэх нь” сэдэвт ЭМЯ дээр болсон хэлэлцүүлэгт оролцлоо.






- Тус ХУЭМТ нь 2019 онд лабораторийн бүрэн засвар үйлчилгээ хийж, ахмадуудын өвчний оношилгоо, шинжилгээг шуурхай явуулахад таатай орчинг бүрдүүлсэн ба шинээр 1,2,3,12,13,8 –р хорооны ӨЭМТ-үүдэд угтах хэсэгтээ электрон даралтны аппарат байрлуулан, видео хичээл явуулж ахмадуудад ээлтэй орчинг үүсгэн ажиллаж байна.
- Монгол Улсын Засгийн Газраас баталсан “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах “ үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Ахмад настан хэрэглэгч”-ийн эрхийг хамгаалах чиглэлээр тодорхой арга хэмжээ зохион байгуулахаар 2019.09.16-2019.10.16 хүртэл “Настнуудын тэгш байдлыг хангацгаая” сэдэвт 1 сарын аяныг ХУЭМТ-ийн ахмадын кабинетээс санаачлан зохион байгуулсан.






Тус сарын аяны зорилго нь ХУД-ийн хүн амын эрүүл насжилтыг дэмжих, настны нийгмийн хөгжилд оролцох оролцоог хангах, тэдний сайн туршлага амжилт, зөв амьдарлын хэв маягийг бусдад сурталчлах, ахмад настанд ээлтэй ӨЭМТ-үүд болох байлаа.

- Ахмадад ээлтэй бүтээлч үйл ажиллагаа явуулсан 16-р хорооны” Энхбуянт манал” ӨЭМТ-ийг 2019 оны “Ахмадад ээлтэй “ ӨЭМТ-өөр шалгаруулж өргөмжлөл олгов.

**“Элэг бүтэн монгол” хөтөлбөрийн хүрээнд:**

| Хийгдсэн ажил | Суурь үзүүлэлт 2015 он | Хүрэх түвшин | | ХУДЭМТ |
|---|---|---|---|---|
| | | 2018 он | 2020 он | 2019 оны жилийн эцэс |
| Улсын хэмжээнд 2 настай хүүхдийн хепатитийн А вирусын эсрэг вакцинаар дархлаажуулах хувь | 97,7% | 98% | 98,5% | 99.1% |
| Эрүүл мэндийн ажилтныг хепатитын В вирусын эсрэг вакцинаар дархлаажуулах хувь | -50% | 75% | 90% | 87.8% |
| Ариутгалын чанарыг биологийн индикатороор ,уурын тархалтыг тестээр хянадаг болсон эрүүл мэндийн байгууллагын эзлэх хувь | 30% | 50% | >70% | 100% |
| Вэб-д суурилсан цахим программд мэдээлэл оруулж хэвшсэн эрүүл мэндийн байгууллагын эзлэх хувь | | 30 | 60 | 100% |
| Нийт хүн амаас хепатитийн В вирусын халдвар илрүүлэх шинжилгээнд хамрагдсан иргэдийн эзлэх хувь | | 40% | 60% | 56.1% |
| Нийт хүн амаас хепатитийн С вирусын халдвар илрүүлэх шинжилгээнд хамрагдсан иргэдийн эзлэх хувь | | 40% | 80% | 56.1% |
| Хепатитийн вирусын архаг халдвартай хүмүүсээс элэгний хорт хавдрын эрт илрүүлэгт хамрагдсан иргэдийн эзлэх хувь | | 30% | 70% | 20% |
| Тухайн жилд хепатитийн В вирусын архаг халдвартай гэж оношлогдсон иргэдээс вирусын эсрэг эмчилгээнд хамрагдсан өвчтөний эзлэх хувь | | 30% | 60% | 21% |
| Тухайн жилд хепатитийн С вирусын архаг халдвартай гэж оношлогдсон иргэдээс вирусын эсрэг эмчилгээнд хамрагдсан өвчтөний эзлэх хувь | | 40% | 60% | 24.5% |
| Хепатитийн В вирусын эсрэг эмчилгээнд хамрагдсан өвчтөнүүдээс вирусын идэвхижил нь дарангуйлагдсан өвчтөний эзлэх хувь | | 75% | 90% | - |
| Хепатитийн С вирусын эсрэг эмчилгээнд хамрагдсан өвчтөнүүдээс вирусын идэвхижил нь дарангуйлагдсан өвчтөний эзлэх хувь | | 80% | 90% | 92% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Шинжлэх ухаан технологийн сангийн санхүүжилтээр хийгдсэн эрдэм шинжилгээ, судалгааны тоо | | 4-6 | 8-10 | - |
| | | Тухайн жилд хөтөлбөрийн хэрэгжилтэд төр, хувийн хэвшлийн байгууллагуудын хамтран хийсэн хяналт – шинжилгээ, үнэлгээний тоо | | 20 | 20 | 3 |

ЭМТ-ийн эрүүл мэндийн даатгалын мэргэжилтэн болон ӨЭМТ –үүд Зорилтот насны иргэдийг www.health.gov.mn цахим хуудсанд асуумж, илрүүлэг шинжилгээ гэсэн дарааллаар илрүүлэг шинжилгээнд хамрагдсан иргэн бүрийн мэдээллийг бүртгэж мэдээллийн сан үүсгэн ажиллаж байна 2017-2019 оны 10 сар хүртэл хугацаанд нийт 31124 хүний мэдээллийн сан үүсгээд байна . Үүнээс 2019 оны эхний 11 сард 9896 хүний мэдээллийг оруулсан байна.

Элэгний В,С вирусын эрт илрүүлгийн үзлэг шинжилгээнд хамрагдсан иргэдээс сайн дураараа хепатит В-вирусын эсрэг дархлаажуулалтад хамрагдах хүсэлтэй иргэдийг ХУЭМТ-ийн дархлаажуулалтын кабинетад дархлаажуулалтад хамруулах ажлыг хийж байгаа бөгөөд 7-10 дугаар сард 1-р тунд 1934 хүн, 2-р тунд 1701, 3-р тунд 55 хүн буюу нийт 3690 хүн/тун вакцинд хамруулсан байна.

“Элэг бүтэн монгол хөтөлбөр”-ийн хүрээнд 2017-2019 онд зорилтот насны 86391 иргэнийг үзлэгт хамруулахаас 36184 /41.9%/ иргэд үзлэгт хамрагдсан. 2019 онд Хан-уул дүүргийн зорилтот насны нийт 36423 иргэнийг үзлэгт хамруулахаас 2019 оны эхний 10 сарын байдлаар 16990 /46.6%/ иргэд эрт илрүүлэгт хамрагдаад байна. 2019 оны эхний 10 сард илрүүлэгт хамрагдсан иргэдээс 379 В вирустэй илэрснээс вирусын ачаалал тоолуулсан-726, эмчилгээнд хамрагдсан-24 /21%/, С вирустэй 576 иргэнээс вирусын ачаалал тоолуулсан- 895, үүнээс эмчилгээнд орсон 151 /24.5%/ байна. Эмчилгээнд орсон С вирустэй иргэдийн 92% нь бүрэн эмчлэгдсэн байна.

Эмчилгээнд хамрагдсан С вирустэй иргэдийн эмчилгээний амжилт 2019 оны хагас жилд 96.2% байсан нь 92% болж буурсан нь 7 сараас хойш эмчилгээнд хамрагдсан хүмүүсийн тоо нэмэгдсэнийг харуулж байна.

Хийгдсэн ажлын ололттой тал:

1. Дүүргийн 15-65 насны иргэдийн В,С вирусын эрт илрүүлэгийн шинжилгээнд хамрагдсан иргэн бүрийн мэдээллийг бүртгэж мэдээллийн сан үүсгэн ажиллаж байна

2. Хепатитийн В,С вирустэй иргэдийн вирусын идэвхжилийг тодорхойлж, эмийн эмчилгээнд эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлттэй нөхцөлөөр хамруулсан.

3.Эмчилгээнд хамрагдсан С вирустэй иргэдийн эмчилгээний амжилт 92%.

4. "Хавдрын эсрэг үндэсний аян-2019"-буюу 9 дэхь аяны нээлтээ Хан-уул дүүрэг дээр хийж 16 хорооны иргэдэд 6 төрлийн хавдрын эрт илрүүлгийн үзлэгийг хийсэн

5. Эрт илрүүлгийн оношлуураар хангагдсан.

Элэгний В,С вирусын эрт илрүүлгийг нэмэгдүүлэхээр “Элэг бүтэн Хан-уул” сарын аяныг хэрэгжүүлэн ажиллаж байна.

**Сэтгэц, наркологийн чиглэлээр :**

Сэтгэцийн эрүүл мэнд наркологийн кабинет хэвтэн эмчлүүлэх тасгийн хөнгөвчлөх эмчилгээ болон хими эмчилгээний эмчлүүлэгч нарт сэтгэл зүйн зөвлөгөө өгч өөрөө өөртөө нөлөөлөх дасгал заалж, сэтгэл гутралын эсрэг тараах материал тараан мөн тэдний ар гэрт сэтгэл зүйн тусламж үзүүлэн ажиллаж байна.
2019 оны байдлаар Сэтгэцийн эрүүл мэнд, наркологийн кабинетаар үйлчлүүлсэн нийт иргэдийн тоо:

- Бүгд үзлэг-7357
- Урьдчилан сэргийлэх үзлэг-6290
- Идэвхитэй хяналт-561

Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ

<table>
<tr><td></td><td colspan="2">Үзүүлэлт</td><td>2019 он</td></tr>
<tr><td>1</td><td colspan="2">Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамрагдсан хүний тоо</td><td>7357</td></tr>
<tr><td>2</td><td colspan="2">Урьдчилан сэргийлэх үзлэгт</td><td>6290</td></tr>
<tr><td>3</td><td colspan="2">Өвчний учир амбулатори</td><td>508</td></tr>
<tr><td>4</td><td colspan="2">Идэвхтэй хяналтанд хянагддаг хүний тоо</td><td>561</td></tr>
<tr><td rowspan="4">5</td><td rowspan="4">ХЧА тогтоолгосон</td><td>Нийт ХЧА тогтоолгосон хүний тоо, үүнээс:</td><td>40</td></tr>
<tr><td>Тэнэгрэл - F01-02</td><td>1</td></tr>
<tr><td>Оюуны хомсдол - F70-79</td><td>23</td></tr>
<tr><td>Солиорох эмгэг - F20-29</td><td>1</td></tr>
</table>

| | | | |
|---|---|---|---|
| | хүний тоо /өвчлөл бүрээр/ | Органик гаралтай сэтгэцийн эмгэг F06-07 | 13 |
| | | Шизоаффектив өөрчлөлт - F30-39 | 1 |
| | | Неврозын хүрээний эмгэг - F45 | 1 |
| | | F48 | - |
| | | F60 | 1 |
| | | Архины шалтгаант сэтгэцийн болон зан үйлийн эмгэг - F10 | 1 |
| 6 | Нийгмийн халамж үйлчилгээнд хамруулсан хүний тоо /Ямар үйлчилгээнд хамруулсан/ | Нийт | 74 |
| | | Байнгын асаргаа /Унааны зардал, түлээ нүүрс олгосон, хүнсний талонд хамруулсан / | 28 |
| | | Эмийн хөнгөлөлт | 46 |
| 7 | Нийгэм хамт олонд тулгуурласан тусламж үйлчилгээний төрөл, хамрагдсан хүний тоо /төрөл бүрээр/ | Нийт хамрагдсан хүний тоо | 11 |
| | | Өөрөө өөртөө туслах бүлэг /хатгамал, шүрэн эдлэл, оёдол, мужаан/ | 11 |
| | | Уулзалт | 1 |

2019 оны байдлаар ХУЭМТ-н сэтгэцийн эрүүл мэнд, наркологийн кабинетаас СЭМҮХ-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран Сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах , хорт зуршлын чиглэлээр нийт 1500 гаруй иргэд оюутан залууст сургалт сурталчилгаа хийсэн. Үүнд:

- ЕБС-700
- Их дээд сургууль ,Коллеж-500
- Сурталчилгааны материал 4 төрлийн нийт 2000 ш тараах материал гарын авлага тараасан
- Төрийн болон төрийн бус байгуулга-100 тус тус сургалт хийсэн байна.

Сэтгэл зүйн зөвлөгөө болон сэтгэл заслын эмчилгээг нийт давхардсан тоогоор 345 удаагийн сэтгэл зүйн зөвлөгөө, сэтгэл засал хийгдсэн байна

-Сэтгэцийн эмгэгтэй хүний хөдөлмөр зохицуулалтын асуудлыг эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын мэргэжил арга зүйн удирдлагын дор нийт- 20 шийдвэрлэсэн ба шинээр- 4 хуучин- 24 байна.

-Халамжийн үйлчилгээнд нийт- 14 иргэнг хамруулсан

НЭМГ-ын харьяа Наркологийн эмнэлэг, Хан-уул дүүргийн II хороотой хамтран Хан-Уул дүүргийн II, XII хорооны ажилтан, ӨЭМТ-ийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, иргэдэд Наркологийн эмнэлгийн үйл ажиллагааг сурталчлах зорилгоор “Ажлаа танилцуулах өдөрлөг”-ийг зохион байгуулж өдөрлөгийн үеэр иргэдэд эрүүл мэндийн үзлэг оношилгоог хийж, сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. Наркологийн эмнэлгийн





зүгээс “Эрүүл иргэн, архидалтгүй эрүүл хороо” бий болгох ажлын хүрээнд ХУД-ийн II дугаар хороотой хамтран 2019 онд архины асуудалтай, өөрийн хүсэлтээр хэвтэн эмчлүүлэх хүсэлтэй, мөн архины хамааралтай хүнтэй хамт амьдарч буй давхар хамааралд өртсөн гэр бүлийн гишүүдийг хэвтүүлэн эмчлүүлэхээр болсон байна.

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал болон Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, дүүргийн Прокурорын газар, Наркологийн эмнэлэгтэй хамтран 6 дээд сургуульд "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис түүний хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх сургалт"-ыг зохион байгуулан хийлээ.







**2019 оны 2-3-р сард :** АРХИДАН СОГТУУРАЛ БА ХҮҮХДИЙН ЭРХ-ХҮҮХЭД ХАМГААЛАЛ, сэдвээр архины хэрэглээтэй гэр бүлийн хүүхдийн сэтгэл зүйг дэмжих зорилгоор БУЦС-ийн 6-8-р ангийн 15 бүлгийн 495, 52-р сургуулийн 8, 9, 10-р ангийн нийт 658 хүүхдүүдэд , 53-р сургуулийн эцэг эх асран хамгаалагч нарт зохион байгууллаа. Нийт 10 бүлгийн 400 гаруй эцэг эх асран хамгаалагч сурагчдад, 75-р сургуулийн ахлах ангийн 34 сурагчдад “Цахим орчнийг зохистой хэрэглэх” нь, Дэлгэцийн донтолтоос сэргийлье” сэдвээр зохион. байгуулж, видео хичээл үзүүлэн, сурагчдаас сургалтын өмнөх болон дараах гэсэн хэлбэрээр мэдлэг шалгах сорил бөглүүлж үр дүнг тооцон ажилласан

.






Архины хамааралтай иргэдийн судалгаа гаргаж нийт 23 иргэн бүртгэгдсэн байна. Мөн их дээд сургуулийн оюутнуудад архи болон тамхины хор хөнөөллийн талаар сургалт сурталчилгааны материал бэлтгэн тараалаа.нийт 256 иргэн оюуттнууд хамрагдсан байна.

  

2019.05.31 нд Дэлхийн тамхигүй өдрийг угтан өдөр бүрийг тамхигүй өдөр болгоцгооё” аяны хүрээнд “Амьсгалах агаараа тамхинд бүү алд” уриан доор тэмдэглэн харъяа 75-р сургуулийн ахлах ангийн нийт 125 хүүхдүүдэд тамхины хор уршиг хүний биед хэрхэн нөлөөлөх талаар сургалт хийж гарын авлага бэлтгэн тарааж сурагчдын дунд АХА тэмцээн зохион байгуулж эхний 3-н байранд орсон сурагчдыг Өргөмжлөл үнэ бүхий зүйлээр шагнаж урамшуулсан.

  

Сэтгэц наркологийн кабинет, Яармаг салбар амбулатори, Яармаг бүсийн - ӨЭМТ-үүд хамтран "ДЭЛХИЙН ТАМХИНЫ ЭСРЭГ ӨДӨР"-ийг тохиолдуулан ХУД-ийн цагдаагийн 1,2-р хэлтсийн 76 -нь албан хаагч, ажилтнуудад "ТАМХИНЫ ИШГҮЙ АЛБАН БАЙГУУЛГА" сэдэвт сургалт, өдөрлөг зохион байгууллаа.

  

<table>
<tr>
<td></td>
<td></td>
<td>

**2019.05.30** “Дэлхийн тамхигүй өдөр"-ийг угтан "Хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, Тамхины хор нөлөө, тамхи эрүүл мэндэд нөлөөлөх нь " сэдэвт сургалтыг зохион байгуулж . Сургалтанд ХУД-н ЕБС-ийн эмч, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан,эрүүл мэндийн хичээл заадаг багш нар нийт 27 хүн хамрагдлаа.




Архидан согтуурахтай тэмцэх аяны хүрээнд Архи тамхи, мансууруулах ,сэтгэц нөлөөт бодисын хэрэглээг илрүүлэх ASSIST сургалт, Архинд донтох өвчин, Оюуны хомсдол өвчний талаар ӨЭМТ-ийн эмч нарт Наркологийн эмчтэй хамтран  сургалт хийлээ.Сургалтанд 18 эмч мэргэжилтэн хамрагдлаа.

  

**2019.06.11-нд** “Дэлгэцийн донтолтоос өсвөр үеийг хамгаалах” сэдэвт сургалтыг 10-р сургуулийн 7,8-р ангийн 64 хүүхдэд зохион байгуулав.

</td>
</tr>
</table>



**2019.06.25-нд** хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Монгол Улсын иргэдийг гадаад улсад зорчихдоо энэ төрлийн гэмт хэрэгт холбогдох мөн хүний гуйвар болон мөнгө амласан ачаа тээш авахгүй байх, авсан тохиолдолд сайтар шалгах тухай сэрэмжлүүлэг мэдээллийг хүргэж 38 иргэнийг хамрууллаа.



**2019.09.06** Гэр бүл төлөвлөт сэдэвт сургалтанд нийт 98 оюутан залуучууд хамрагдаж гэр бүл төлөвлөлтийн талаар мэдлэгтэй болсон.

Дүгнэлт:

2019 оны жилийн эцсийн байдлаар Сэтгэцийн эрүүл мэнд, наркологийн кабинетаар үйлчлүүлсэн нийт иргэдийн тоо:

- **Бүгд үзлэг-7357**
- **Урьдчилан сэргийлэх үзлэг-6290**

| | | |
|---|---|---|
| | | • **Идэвхитэй хяналт-561**<br><br>**Сэтгэл зүйн зөвлөгөө болон сэтгэл заслын эмчилгээг нийт давхардсан тоогоор 357 удаагийн сэтгэл зүйн зөвлөгөө, сэтгэл засал хийгдсэн байна** |
| | | **Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд амны хөндийн эрүүл мэндийн үзлэг хийх явуулын үйлчилгээг идэвхжүүлэх зорилтын хүрээнд :**<br><br>➢ 2019 онд нийт 8266 хүүхдэд амны хөндийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж, анхдагчаар 5621 хүүхэд үйлчлүүлснээс 2866 буюу 51% нь эрүүлжүүлсэн байна. Энэ нь урд оноос 2%-р өссөн үзүүлэлттэй байна.<br>➢ “Эрүүл шүд- Эрүүл хүүхэд ” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ХУЭМТөвийн шүдний кабинетүүдийн урьдчилан сэргийлэх үзлэгээс эрүүлжүүлсэн бүтээлч ажил болох:<br>➢ Хамгийн их шүд цоорлын өвчлөлтэй гарсан 32-р сургуулийн 4б ангийн хүүхдүүд болон зорилтот бүлгийн хүүхдүүд хүмүүждэг халамжийн 28-р цэцэрлэгийн бэлтгэл ангийнхныг 100% эрүүлжүүлэн "Эрүүл шүдтэй анги" өргөмжлөл гардуулан өглөө.<br>➢ 115,18-р сургуулийн зорилтот бүлгийн 70 хүүхэд, зорилтот бүлгийн 3 өрхийн бага насны 8 хүүхдийг бүрэн эрүүлжүүллээ.<br>➢ Хан-Уул дүүргийн цагдаагийн нэгдүгээр хэлтсийн албан хаагчдын хүүхдүүдийг амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан, эмчлэн эрүүлжүүлэх ажил хийгдэж 12 хүүхдийг бүрэн эрүүлжүүлсэн байна.<br>➢ ХУД-ийн 28,53-р цэцэрлэгийн 12 багшийн амны хөндийг бүрэн эрүүлжүүлэн, сургалт хийж, амны хөндийн эрүүл мэндийн сургагч багшаар бэлдлээ.<br>➢ Нийт урьдчилан сэргийлэх үзлэгээс 947 хүүхэд буюу 12,8% нь эрүүлжсэн байна.Энэ нь өмнөх онтой харьцуулбал 0,2%-р өссөн үзүүлэлттэй байна.<br>➢ ӨЭМТ-үүдийн хийсэн амны хөндийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгээс амны хөндийн өвчлөлтэй илэрсэн хүүхдүүдийг эрүүлжүүлэх ажил хийгдэж, нийт 1256 хүүхэд эмчилгээнд хамрагдсан байна. |

Урьдчилан сэргийлэх үзлэг хийсэн байдал

- *2018 он* - *2019 он*

| Эмнэлэг | Хийгдсэн газар | | Хамрагдсан хүний тоо | | Өвчтэй илэрсэн | | Тархалт | | Эрчим | | Үзлэгээс эрүүлжсэн | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| ХУЭМТ Амбулатори №1 | 29,46,71,73,230,35,218 цэцэрлэг 7,52,15,75,32,130,118,34,41,60 сургууль | 115,18,32,34,41,118,7-р сургууль 29,28,35,189,71,27,41,35,73,12,219,145,134,243,209 цэцэрлэг,Төв цэнгэлдэх,Хороо | 7303 | 9136 | 5710 | 7400 | 78,2% | 81% | 5 | 6,1 | 719 (12,6%) | 947 12,8% |
| Шүдний кабинетүүд нийт | 7 цэцэрлэг 10 сургууль | 7 сургууль 15 цэцэрлэг | | | | | | | | | | |
| ӨЭМТөвүүд | | 67,53,46,28,41,12,14,29,121,35,190,49,223,243,23,219,230,250,"Очхон”,"Амин ирээдүй",” Орхон”,"Бяцхан шилтгээн","Шинэ идэр" цэцэрлэг,52,34,118,32,10,135,БУЦ сургууль,”,"Амин найзууд",ӨЭМТ | | 16098 | | 13039 | | | | | | |
| Нийт | 7 цэцэрлэг 10 сургууль | 38 цэцэрлэг,14 сургууль | | 25234 | | 20439 | | | | | | |

➢ Шүдний кабинетүүд зориудын урьдчилан сэргийлэх үзлэгээр ХУД-ийн харъяа 7 сургууль,15 цэцэрлэг, Төв цэнгэлдэх хүрээлэн дээр зохион байгуулагдсан ”Эрүүл аз жаргалтай ирээдүй” өдөрлөгийн

| | | |
|---|---|---|
| | | арга хэмжээн дээр оролцсон хөгжлийн бэрхшээлтэй 118 хүүхэд, ХУД-ийн яармаг бүсийн 4,5,6,7,8-р хороодын хөгжлийн бэрхшээлтэй 205 хүүхэд, нийт 9136 хүүхдийг амны хөндийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, цэцэрлэгүүд дээр болон хороод дээр эцэг эхийн зөвшөөрөлтэйгээр шүдний цоорлоос урьдчилан сэргийлэх үйлчилгээтэй Бразил улсад үйлдвэрлэсэн фторт түрхлэгийг 1705 хүүхдийн шүдэнд түрхлээ. Мөн цэцэрлэгийн 18 багш ажилчдыг үзлэгт хамруулж фторт түрхлэг түрхсэн байна.<br>➢ ХУД-ийн харъяа 35,27,41 болон халамжийн 28-р цэцэрлэгийн шүд цоорлын өвчлөл хамгийн их илэрсэн бэлтгэл, ахлах ангийн 323 хүүхдийн өнгөц ба дунд цооролтой шүднүүд дээр цоорол зогсоох Saforaid түрхлэгийг түрхэн, шүдний өвчлөлийн цаашдын хүндрэлээс урьдчилан сэргийллээ. ХУД-ийн харъяа 32,115,34-р сургууль,35-р цэцэрлэгийн үзлэгийг тус хороодын ӨЭМТөвийн эмч нартай хамтран хийлээ.<br>➢ ӨЭМТөвүүд 8 сургууль,24 цэцэрлэгийн нийт 16098 хүүхдийг амны хөндийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан байна.<br>➢ ХУД-ийн хэмжээнд нийт 25234 хүүхдийг амны хөндийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан байна. |
| | | **Сүрьеэгийн идэвхтэй эрт илрүүлгийг сайжруулах зорилгоор ӨЭМТ -үүдтэй хамтарч халдварт өвчний тандалт, судалгааг хийж, өвчлөлийг бууруулах арга хэмжээг зохион байгуулах, эртэмтгий бүлгийн иргэдийг жилд нэг удаа урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах зорилтын хүрээнд :**<br><br> |

**Хавьтлын үзлэгт оруулсан байдал 2019 оны эхний 10 сарын байдлаар**

| Хороо | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 | Дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Нийт өвчлөл** | 4 | 9 | 27 | 21 | 11 | 17 | 13 | 9 | 13 | 25 | 14 | 7 | 10 | 9 | 18 | 23 | 230 |
| **Нийт хавьтал** | 10 | 23 | 95 | 45 | 22 | 44 | 32 | 18 | 34 | 64 | 35 | 24 | 25 | 27 | 41 | 55 | 594 |
| **Үзлэгт орсон** | 8 | 23 | 86 | 35 | 15 | 40 | 28 | 17 | 31 | 53 | 29 | 20 | 20 | 23 | 34 | 52 | 514 |
| **Хамрагдсан хувь** | 80 % | 100 % | 91 % | 78 % | 68 % | 91 % | 87 % | 94 % | 91 % | 83 % | 88,5 % | 83 % | 80 % | 85 % | 83 % | 95 % | 86% |

2019 оны 10-р сарын байдлаар сүрьеэ өвчний шинэ 175 тохиолдол бүртгэгдэж 10,000 хүн амд 10 байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад:

- 20 тохиолдлоор буурсан,
- 10000 хүн амд мөн 1,8 промилоор буурсан байна.

Сүрьеэ диспансерийн үйл ажиллагаанд нийт 59,740,000 төгрөг зарцуулснаас 31,335,000 төгрөгийг төсвөөс, 28,405,000 төгрөг глобал сангаас гаргуулан ажилласан.

- Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, бичгийн хэрэгсэл, лабораторийн урвалж, шинжилгээний сав, ариутгалын бодис зэрэгт байгууллагын төсвөөс 2,895,000 төгрөг
- Эмийн зардалд улсын төсвөөс 25,745,000 төгрөг, глобал сангаас 24,855,000 төгрөг гаргуулан ажилласан.
- Түрхэцийн шинжилгээнд төсвөөс спирт 120,000төг, тавиур шил 1.210.000төг, марль, цэрний сав 1.290.000төг, бээлий 60000 төг,цэвэрлэгээний бодис 15000 төг зэрэгт нийт 2.695.000 төгрөг.
- Глобаль сангаас аурамин, фенол, калий перманганат, давсны хүчил зэрэгт 855500 төгрөгийг тус тус зарцуулсан.
- Халдвар хамгааллын хэрэгсэл N-95 маскыг 7 хоногт нэг мэргэжилтэн 2 ш хэрэглэж хэвшсэн.

Сүрьеэгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нийслэлд сайжруулах, идэвхитэй эрт илрүүлэг, сүрьеэгийн хавьтал илрүүлгийн ажлыг эрчимжүүлэх зорилгоор НЗД-ын “Сүрьеэгийн эрт илрүүлгийг нэмэгдүүлж, эмчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлье” А/319 захирамжийн дагуу Хан-Уул дүүргийн ЗД-ын А/200 тоот захирамж гаргуулж шаардагдах тоног төхөөрөмж, материалын төсөв хүргүүлэн 850,000

| | | |
|---|---|---|
| | | төгрөгний үнэ бүхий газрын зураг, 2,300,000 төгрөгний иж бүрэн дагалдах хэрэгсэл бүхий компьютер, А сургуульд 9,000,000 төгрөгний үнэ бүхий 30 ширхэг кварц, эмчилгээ хийлгэж буй хүүхдүүдэд 1,450,000 төгрөгний элэг хамгаалах эм, 11,320,000 төгрөгний үдийн цайнд хамруулж, 30,000,000 төгрөгний үнэ бүхий 75 ширхэг вакум цонх болон 30,000,000 төгрөгөөр заалны засварыг хийлгэсэн. Оюутан сурагчдын дунд АСТ тэмцээн, явган аялал зохион байгуулж 400,000 төгрөгний төсвийг дүүргийн ЗДТГ-аас санхүүжүүлсэн.<br><br>Сүрьеэгийн эрт илрүүлэг, оношлогоог эрчимжүүлэх, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулахаар дараах зохион байгуулалтын арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүллээ. Үүнд:<br><br>· Сүрьеэгийн эмчилгээ болон урьдчилан сэргийлэх эмчилгээнд хамрагдах хүүхдүүдийн эцэг, эх, асран хамгаалагчтай ганцаарчилсан уулзалтын өрөөг сүрьеэгийн диспансераас тусад нь зохион байгуулж, мэдээллийн зөрүү, эмх замбараагүй байдал үүсэхээс сэргийлэн, үнэн зөв, цэгцтэй зөвлөгөө мэдээлэл өгөх үйл ажиллагааг зохицуулагч эмч Э.Пагамсүрэн хариуцан ажилласан.<br>· Тус сургуулийн эцэг эхчүүдийн фэйсбүүк сүлжээнд сүрьеэ өвчин, урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар бичлэг хийж байршуулсан.<br>· Сүрьеэгийн диспансерийн эмч, сувилагч тусгай мэргэжилтнүүд 5-7 сард ачаалалтай, уртасгасан цагаар ажиллаж, ажлын ачааллыг хөнгөвчлөх зорилгоор их эмч, тархвар судлаач орон тоогоор, 2 сувилагч дотоод нөөцөөс гаргуулан ажилласан.<br>· Эмчилгээ хяналт, хавьтлын үзлэг шинжилгээнд дуудах суурин утас 2019 оны 6,7 сард байрлуулсан.<br>· Хавьтлын үзлэгийг эрчимжүүлэхийн тулд рентген кабинетийг2019 оны 5,6 сард 2 ээлжээр 08:30-19:00 цаг хүртэл ажиллуулсан.<br>· Эмчилгээ хяналтын ЦЕШ, ШЕШ, БХШинжилгээг хүлээгдэлгүй өдөр бүр хүлээж авч байна. Эмчилгээний эхний сарын Биохими, шээсний ерөнхий шинжилгээнд 236 хүүхэд хамрагдаж, элэгний шинжилгээнд өөрчлөлттэй 7 хүүхдээс 6 нь эмчлэгдэж эмээ уусан. 1 хүүхдийн эмийг түр зогсоон эмчилгээ хийж элэгний үйл ажиллагаа хэвийн болсон боловч эмээ уухаас татгалзсан байна. 2 дахь сарын шинжилгээнд эдгээр хүүхдээс 2019 оны 11-р сарын 08-ны байдлаар 171 хүүхэд шинжилгээ өгсөнөөс элэгний шинжилгээнд өөрчлөлттэй нийт 2 хүүхдэд элэгний эмчид үзүүлэн эмийн эмчилгээ зөвлөсөн.<br>· 2019 оны 5,6,7-р сард Туберкулины арьсны сорилыг 1 өдөр нэмж, долоо хоногт даваа, баасан гарагуудад 2 удаа тавьсан.<br><br>**Идэвхтэй эрт илрүүлэг:**<br><br>“Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр”-ийн дагуу бүх хэлбэрийн сүрьеэгийн илрүүлэлтийн хувийг улсын хэмжээнд 2020 онд 45%-д хүргэхээр зорьж байна. Хан-Уул дүүргийн хэмжээнд |

2018 оны байдлаар 41% байсан ба 2019 оны эхний 10 сарын байдлаар 40%-д хүргэн ажиллалаа.

- ЭМС-ын 2017 оны 306 тушаалын дагуу эрсдэлт бүлгийн судалгааг 5 чиглэл, 22 бүлгээр 9800 хүний судалгааг шинэчлэн гаргаж нэгтгэсэн. 2019 оны 10-р сард өрхийн 514, ойрын 2850 нийт 3364 хавьтал үзлэгт хамрагдаад байна.
- 2019 оны эхний 10 сард оношлогдсон сүрьеэгийн 230 тохиолдлын нийт 594 хавьтлаас 514 хүн хавьтлын үзлэг шинжилгээнд хамрагдаж 11 тохиолдол сүрьеэгийн үндсэн эмчилгээнд орж 31 тохиолдол урьдчилан сэргийлэх эмчилгээнд хамрагдсан.

2018-2019 оны хичээлийн жилд сүрьеэгийн өвчлөл бүртгэгдсэн 7 ерөнхий боловсролын сургууль, 1 цэцэрлэгийн 2850 багш сурагчдыг 2019 оны 03-05 сард үзлэгт хамруулж, шинэ сүрьеэгийн 38 тохиолдол илрүүлж, эмчилгээнд хамруулсан.





| № | Хүүхдийн байгууллага | Хамрагдвал зохих | Хамрагдсан | | | Рентген | Сорилд хамрагдсан | Сорил өндөр гарсан | Цэрний шинжилгээ | Шинэ илэрсэн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | нийт | Багш | Сурагч | | | | | |
| 1 | 15-р сургууль | 1848 | 1756 | 111 | 1645 | 938 | 1702 | 607 | 73 | 37 |
| 2 | 32-р сургууль | 418 | 380 | 63 | 317 | 380 | 329 | 134 | 16 | 1 |
| 3 | 7-р сургууль | 566 | 425 | 89 | 336 | 181 | 336 | 38 | 5 | 0 |
| 4 | 26-р сургууль | 50 | 41 | 41 | 0 | 41 | 0 | 0 | 4 | 0 |
| 5 | 60-р сургууль | 96 | 70 | 70 | 0 | 70 | 0 | 0 | 5 | 0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | 71-р цэцэрлэг | 47 | 28 | 0 | 28 | 14 | 28 | 14 | 2 | 0 |
| 7 | 130-р сургууль | 35 | 25 | 25 | 0 | 25 | 0 | 0 | 0 | 0 |
| 8 | 115-р сургууль | 135 | 125 | 73 | 52 | 73 | 52 | 8 | 4 | 0 |
| 9 | Нийт | 3195 | 2850 | 472 | 2378 | 1722 | 2447 | 801 | 109 | 38 |

Илрүүлгээр хийсэн сорилын дүгнэлт 2019 оны эхний 10 сарын байдлаар

| Сургууль | анги | Сурагч | Сорилдхамргадсан | эерэг | хувь |
|---|---|---|---|---|---|
| 15-р сургууль | 1-5 | 1139 | 1084 | 240 | 22,1% |
| 15-р сургууль | 6-12 | 592 | 534 | 336 | 62,9% |
| 15-р сургууль | багш | 109 | 49 | 23 | 46,9% |
| 115-р сургууль | 4г | 39 | 33 | 3 | 8% |
| 115-р сургууль | 3д | 27 | 19 | 5 | 26% |
| 71-р цэцэрлэг | Ахлах а | 47 | 28 | 0 | 0% |
| 7-р сургууль | 1д | 54 | 43 | 12 | 28% |
| 7-р сургууль | 2е | 49 | 42 | 4 | 9% |
| 7-р сургууль | 3д | 44 | 42 | 10 | 23% |
| 7-р сургууль | 4б | 43 | 40 | 9 | 22% |
| 7-р сургууль | 5е | 49 | 45 | 2 | 5% |
| 7-р сургууль | 4ё | 41 | 36 | 1 | 2% |
| 7-р сургууль | 7в | 40 | 40 | 3 | 8% |
| 7-р сургууль | 8б | 34 | 31 | 3 | 9% |
| 32-р сургууль | 7а | 30 | 27 | 5 | 18% |
| 32-р сургууль | 7б | 29 | 27 | 3 | 11% |
| 32-р сургууль | 7в | 34 | 29 | 7 | 24% |
| 32-р сургууль | 8а | 37 | 36 | 12 | 33% |
| 32-р сургууль | 8б | 26 | 24 | 2 | 8% |
| 32-р сургууль | 8в | 32 | 28 | 5 | 18% |
| 32-р сургууль | 9а | 25 | 20 | 11 | 55% |
| 32-р сургууль | 9б | 37 | 26 | 14 | 54% |
| 32-р сургууль | 10а | 17 | 17 | 9 | 53% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 32-р сургууль | 10б | 26 | 21 | 13 | 62% |
| 32-р сургууль | 11а | 23 | 16 | 13 | 81% |
| 32-р сургууль | 11б | 27 | 21 | 6 | 28% |
| 32-р сургууль | 12а | 12 | 9 | 6 | 66% |
| 32-р сургуулиас илрүүлэг үзлэгээр ЭТСүрьеэ оношлогдсон багшийн анги болон смен ангийн сорилын үнэлгээ /1е/ | | | | | |
| 32-р сургууль | 3б | 35 | 31 | 5 | 16% |
| 32-р сургууль | 1е | 36 | 34 | 2 | 5% |

Үзлэг шинжилгээ

| Илрүүлэг шинжилгээ үзлэг | 2018 оны эхний 10 сараар | 2019 оны эхний 10 сараар |
|---|---|---|
| Бүгд үзлэг | 6600 | 12995 |
| Шинэ сүрьеэ | 195 | 175 |
| Хүүхдийн сүрьеэ | 19 | 40 |
| Флюр шинжилгээ | 9144 | 11192 |
| Түрхэцийн шинжилгээ | 1183 | 1270 |
| Үүнээс: шинэ түрхэц эерэг гарсан | 115 | 143 |
| ЭМЧТ | 168 | 148 |
| G- хрерт | 156 | 207 |
| Туберкулины сорил тавьсан | 1079 | 3094 |
| **Хавьтлын шинжилгээнд хамралт** | **80,1%/398 -320/** | **86% /594-514** |

ДОТС-ийн эмчилгээ хяналт

| Шууд хяналтай богино хугацааны эмчилгээ хяналт | 2018 оны эхний 10 сар /тохиолдлын тоо/ | 2019 оны эхний 10 сар /тохиолдлын тоо/ |
|---|---|---|
| Диспансерын хяналтанд эм ууж байгаа | 106 | 115 |
| СКЭ хэвтэж байгаа өвчтөний тоо | 34 | 34 |
| ӨЭМТ-д дотс-ын эмчилгээг хяналттай хийгдэж байгаа өвчтөний тоо | 43 | 43 |
| СДИ гэртээ хүргүүлж эмчилэгдэж байгаа байгаа | 34 | 29 |
| ЭТС өдрийн эмчилгээний цэгт эмчлэгдэж байгаа | 31 | 26 |

| Нийт | 248 | 247 |
|---|---|---|

Урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээ

| № | Албан газар | Хамрагдсан хүн | № | Албан газар | Хамрагдсан хүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | Нью булл | 52 | 55 | 118-р сургууль | 42 |
| 2 | Корпорэте нүхт | 31 | 56 | Монголдой цэцэрлэг | 19 |
| 3 | Централ товер | 44 | 57 | 73-р цэцэрлэг | 34 |
| 4 | Ти энд ти блэк | 24 | 58 | Шар доктор | 28 |
| 5 | Номин кидс | 13 | 59 | Номадс хоспитал | 46 |
| 5 | Ази фарм | 29 | 60 | ММС поларис | 44 |
| 6 | Миат | 207 | 61 | Скай хайпермаркет | 140 |
